



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
БҮСИЙН ЗАХИРГААНЫ 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/350/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх
аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 261628 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Төгс нягт гурав аудит ХХК
Захирал: Д.Цэнд
Цахим хаяг: tsenddorjkhoroov@gmail.com

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ^[OBJ]	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа	18
4.2 Төлбөрийн акт	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын Хоёрдугаар Газар
НА	Нийцлийн Аудит
НББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ТШЗ	Төсвийн Шууд Захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн Осол Мэргэжлээс Шалтгаалах Өвчин
ХХААХҮЯ	Хүнс Хөдөө Аж Ахуй Хөнгөн Үйлдвэрийн Яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

**ХӨДӨӨ АЖ АХУЙН ХАЛХ ГОЛ
ҮНДЭСНИЙ БҮТЭЭН БАЙГУУЛАЛТЫН
БҮСИЙН ЗАХИРГААНЫ ЗАХИРАЛ
О.ОТГОНБЯАР ТАНАА**

2022.02.25 № 07/361
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>479,876,425.79</u>	<u>526,700,376.36</u>
33	АВЛАГА	4,875,607.00	1,660,447.61
335	Бусад авлага	4,875,607.00	1,660,447.61
3351	Байгууллагаас авах авлага	1,550,000.00	1,660,447.61
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3,325,607.00	-
34	УРЬДЧИЛГАА	-	7,200,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	7,200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	475,000,818.79	517,839,928.75
351	Түүхий эд материал	396,704,878.75	396,704,878.75
35110	Тусгай зориулалттай материал	396,704,878.75	396,704,878.75
354	Хангамжийн материал	24,325,940.04	19,095,050.00
35410	Бичиг хэргийн материал	1,719,420.00	1,823,940.00
35420	Аж ахуйн материал	5,457,820.00	4,876,110.00
35440	Түлш, шатах тослох материал	200,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	16,948,700.04	12,395,000.00
35600	Мал амьтад	53,970,000.00	102,040,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,376,190,009.27</u>	<u>1,246,925,817.98</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,376,190,009.27	1,246,925,817.98
392	Биет хөрөнгө	1,374,090,009.31	1,245,692,484.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,400,754,673.00	2,450,204,127.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,117,973,085.55)	(1,250,048,407.03)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	150,670,407.00	150,670,407.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(107,005,511.55)	(125,889,525.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	473,513,139.12	472,344,139.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	(436,641,244.76)	(459,917,875.77)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,494,250.60	30,254,450.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(20,155,951.90)	(21,924,831.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,120,000.00	3,120,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,686,666.65)	(3,120,000.00)
393	Биет бус хөрөнгө	2,099,999.96	1,233,333.32
39301	Програм хангамж	-	2,600,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,366,666.68)
39303	Бусад биет бус хөрөнгө	3,370,000.00	-
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,270,000.04)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,856,066,435.06</u>	<u>1,773,626,194.34</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>62,384.40</u>	=
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	62,384.40	-

413	Өглөг	62,384.40	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	62,384.40	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,856,004,050.66</u>	<u>1,773,626,194.34</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,856,004,050.66	1,773,626,194.34
512	Хуримтлагдсан үр дүн	1,856,004,050.66	1,773,626,194.34
51210	Өмнөх үеийн үр дүн	2,032,111,947.54	1,856,072,650.66
51220	Тайлант үеийн үр дүн	(176,107,896.88)	(82,446,456.32)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,856,066,435.06</u>	<u>1,773,626,194.34</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	422,517,324.24	528,778,554.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	24,044,824.24	113,182,454.00
120	Нийтлэг татварын бус орлого	24,044,824.24	113,182,454.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,044,824.24	113,182,454.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	80,400.00	46,530,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	49,449,454.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	23,964,424.24	17,168,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,472,500.00	415,596,100.00
1310	Улсын төсвөөс	398,472,500.00	415,596,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	398,472,500.00	415,596,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	594,444,665.46	611,225,010.32
21	УРСГАЛ ЗАРДАЛ	594,444,665.46	611,225,010.32
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	569,357,391.32	561,515,786.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	236,812,510.00	264,353,249.70
210101	Үндсэн цалин	236,812,510.00	160,638,707.85
210102	Нэмэгдэл	-	55,752,376.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	28,376,000.00
210104	Урамшуулал	-	14,090,885.85
210105	Гэрээт ажлын хөлс	-	5,495,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,657,311.16	34,995,038.49
210201	Тэтгэврийн даатгал	21,074,767.16	24,576,382.99
210202	Тэтгэмжийн даатгал	2,479,385.00	3,080,703.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,902,869.00	2,105,137.62
210204	Ажилгүйдлийн даатгал	472,754.00	475,710.32
210205	Эрүүл мэндийн даатгал	4,727,536.00	4,757,103.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,660,496.45	1,360,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,160,496.45	-
210304	Байрны түрээс	500,000.00	1,360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,840,220.54	31,982,508.30
210401	Бичиг хэрэг	2,197,880.00	1,013,580.00
210402	Тээвэр, шатахуун	8,132,593.00	4,508,944.39
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,102,837.05	2,819,123.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,444,317.24	5,532,160.00
210408	Бараа материал акталсны зардал	1,962,593.25	1,160,000.00

210410	Бараа материал худалдан авахад төлсөн /ТӨҮГ/	-	16,948,700.04
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	382,600.00	2,485,400.00
210604	Урсгал засвар	382,600.00	2,485,400.00
2107	Томилолт, зочны зардал	8,869,250.00	20,022,215.00
210702	Дотоод албан томилолт	8,869,250.00	20,022,215.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	37,664,670.94	22,440,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,789,670.94	12,833,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	535,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,000.00	428,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	3,600,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	220,470,332.23	183,876,545.29
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	969,651.00	5,162,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	219,500,681.23	178,713,645.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,087,274.14	49,709,223.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,234,850.00	16,598,850.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,771,400.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	13,056,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,463,450.00	3,542,250.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,852,424.14	33,110,373.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,852,424.14	33,110,373.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(171,927,341.22)</u>	<u>(82,446,456.32)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,180,555.66	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,180,555.66	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(4,180,555.66)	-
6	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(176,107,896.88)</u>	<u>(82,446,456.32)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон				/төгрөгөөр/
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	2,029,754,661.98	2,029,754,661.98
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	2,357,285.56	2,357,285.56
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	2,032,111,947.54	2,032,111,947.54
Тайлант үеийн үр дүн	-	-	(176,107,896.88)	(176,107,896.88)
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,856,004,050.66	1,856,004,050.66
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	68,600.00	68,600.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,856,072,650.66	1,856,072,650.66
Тайлант үеийн үр дүн	-	-	(82,446,456.32)	(82,446,456.32)
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,773,626,194.34	1,773,626,194.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>562,849,275.00</u>	<u>415,631,100.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	164,201,606.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	164,201,606.00	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	164,201,606.00	35,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	-	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	164,201,606.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	398,647,669.00	415,596,100.00
1310	Улсын төсвөөс	398,472,500.00	415,596,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	398,472,500.00	415,596,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	175,169.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	175,169.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>561,749,275.00</u>	<u>415,631,100.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	561,749,275.00	415,631,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	536,662,000.86	365,824,126.46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	264,415,637.50
210101	Үндсэн цалин	-	169,777,858.40
210102	Нэмэгдэл	-	48,781,617.25
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	27,466,069.00
210104	Урамшуулал	-	12,894,812.85
210105	Гэрээт ажлын хөлс	-	5,495,280.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	34,897,285.09
210201	Тэтгэврийн даатгал	-	24,827,114.94
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,732,221.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,105,137.36
210204	Ажилгүйдлийн даатгал	-	475,710.32
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,757,100.54
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,660,496.45	1,360,000.00
210301	Гэрэл, цахилгаан	1,160,496.45	-
210304	Байрны түрээс	500,000.00	1,360,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,812,737.05	10,691,523.87
210401	Бичиг хэрэг	3,260,100.00	1,576,100.00
210402	Тээвэр, шатахуун	6,949,800.00	4,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	3,102,837.05	2,819,123.87
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,000.00	2,046,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	596,850.00	6,042,850.00

210604	Урсгал засвар	596,850.00	6,042,850.00
2107	Томилолт, зочны зардал	17,330,750.00	20,846,000.00
210702	Дотоод албан томилолт	17,330,750.00	20,846,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	503,261,167.36	27,570,830.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	502,233,167.36	10,763,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	153,000.00	535,830.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	387,000.00	428,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	400,000.00	10,800,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,087,274.14	49,806,973.54
2132	Бусад урсгал шилжүүлэг	17,234,850.00	16,696,600.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	14,771,400.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	13,056,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,463,450.00	3,640,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,852,424.14	33,110,373.54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,852,424.14	33,110,373.54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>1,100,000.00</u>	-
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	=	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>1,100,000.00</u>	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,100,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	1,100,000.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,100,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(1,100,000.00)</u>	=
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	415,596,100.00	382,520,726.46	33,075,373.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	415,596,100.00	382,520,726.46	33,075,373.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	398,899,500.00	365,824,126.46	33,075,373.54
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	291,836,600.00	264,415,637.50	27,420,962.50
210101	Үндсэн цалин	181,937,800.00	169,777,858.40	12,159,941.60
210102	Нэмэгдэл	47,272,700.00	48,781,617.25	(1,508,917.25)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	35,805,800.00	27,466,069.00	8,339,731.00
210104	Урамшуулал	20,880,300.00	12,894,812.85	7,985,487.15
210105	Гэрээт ажлын хөлс	5,940,000.00	5,495,280.00	444,720.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,398,000.00	34,897,285.09	4,500,714.91
210201	Тэтгэврийн даатгал	27,724,500.00	24,827,114.94	2,897,385.06
210202	Тэтгэмжийн даатгал	2,918,400.00	2,732,221.93	186,178.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,334,700.00	2,105,137.36	229,562.64
210204	Ажилгүйдлийн даатгал	583,700.00	475,710.32	107,989.68
210205	Эрүүл мэндийн даатгал	5,836,700.00	4,757,100.54	1,079,599.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,360,000.00	1,360,000.00	-
210304	Байрны түрээс	1,360,000.00	1,360,000.00	-
2104	Хангамж, бараа материалын зардал	10,883,500.00	10,691,523.87	191,976.13
210401	Бичиг хэрэг	1,646,100.00	1,576,100.00	70,000.00
210402	Тээвэр, шатахуун	4,283,300.00	4,250,000.00	33,300.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	2,824,100.00	2,819,123.87	4,976.13
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,130,000.00	2,046,300.00	83,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,695,200.00	6,042,850.00	652,350.00
210604	Урсгал засвар	6,695,200.00	6,042,850.00	652,350.00
2107	Томилолт, зочны зардал	21,153,300.00	20,846,000.00	307,300.00
210702	Дотоод албан томилолт	21,153,300.00	20,846,000.00	307,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	27,572,900.00	27,570,830.00	2,070.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,765,000.00	10,763,000.00	2,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	535,900.00	535,830.00	70.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	428,000.00	428,000.00	-

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,800,000.00	10,800,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,696,600.00	16,696,600.00	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,696,600.00	16,696,600.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	13,056,600.00	13,056,600.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,640,000.00	3,640,000.00	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	415,596,100.00	382,520,726.46	33,075,373.54
12200	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	415,596,100.00	382,520,726.46	33,075,373.54
122005	Улсын төсвөөс	415,596,100.00	382,520,726.46	33,075,373.54
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	22	22	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	22	
620001	Удирдах ажилтан	1	1	
620002	Гүйцэтгэх ажилтан	20	20	
620004	Гэрээт ажилтан	1	1	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, загварын аж ахуй дахь хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 15-ны хооронд Төгс нягт гурав аудит ХХК-ийн аудитор З.Тунгалаг, аудиторын туслах Ч.Билгүүнзаяа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Я.Пүрэвсүрэн, захирал Д.Цэнд нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь бүс нутагт бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг хослуулан хөгжүүлж, малын өвчингүй тайван бүсийг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлж, дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулах үйлдвэрийг байгуулан, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Байгаль орчинд ээлтэй, экспортын баримжаатай бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх;
- Газар тариалангийн эрчимжсэн аж ахуйг хөгжүүлэх;
- Дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрийг байгуулан, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор батлагдсан “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “их” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 598,625.2 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 2,993.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг тооцох суурь үзүүлэлт, эрсдэлийн үнэлгээ өөрчлөгдөөгүй тул материаллаг байдлын түвшинг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 611,225.0 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 3,056.1 мянган төгрөгөөр тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,440.2 мянган төгрөгөөр буюу 4.4 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	4,875.6	1,660.4	(3,215.2)
Урьдчилгаа	-	7,200.0	7,200.0
Бараа материал	475,000.8	517,840.0	42,839.2
Үндсэн хөрөнгө	1,376,190.0	1,246,925.8	(129,264.2)
Нийт хөрөнгө	1,856,066.4	1,773,626.2	(82,440.2)

Өр төлбөр	62.4	-	(62.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,856,004.0	1,773,626.2	(82,377.9)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,856,066.4	1,773,626.2	(82,440.2)

Авлага дансны үлдэгдэл 1,660.4 мянган төгрөг болж 3,215.2 мянган төгрөгөөр буурсан нь хувь хүн, байгууллагаас авах авлагыг барагдуулсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд он удаан жил болсон авлага байхгүй бөгөөд 1,660.4 мянган төгрөгийн ажилчдаас авах авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 517,840.0 мянган төгрөг болж, 42,839.2 мянган төгрөгөөр өссөн нь 17,168.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан, 11,499.8 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, биологийн хөрөнгө 46,530.0 мянган төгрөгөөр нас дэвшилт хийж нэмэгдсэн, 32,358.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан зэргээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй илүү нөөцөлсөн хөрөнгө байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,246,925.8 мянган төгрөг болж, 129,264.2 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны 6 сарын 4-ний өдрийн А-1/925 тоот зөвшөөрлөөр 2,178.8 мянган төгрөгийн компьютер, техник хэрэгсэл, санхүүгийн программыг акталж, данснаас хассан, дээд шатны төсөв захирагчийн хөрөнгө оруулалтаар хөрөнгийн сайжруулалт хийж 49,449.5 мянган төгрөгийн хөрөнгө орлогод бүртгэж, тайлант онд 179,863.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан зэргээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 62.4 мянган төгрөгөөр буурсан нь хүн амын орлогын албан татварын өглөгийг барагдуулсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,773,626.2 мянган төгрөг болж, 82,377.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалсан байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 106,261.2 мянган төгрөгөөр буюу 25.1 хувиар өссөн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 17,123.6 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 35.0 мянган төгрөг, ХХААХҮЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хүлээн авсан 49,449.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 17,168.0 мянган төгрөгийн бараа материал болон 46,530.0 мянган төгрөгийн биологийн хөрөнгө нас дэвшилт хийж нэмэгдсэн орлого зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 16,780.4 мянган төгрөгөөр буюу 2.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин шимтгэлийн зардал, томилолтын зардал, тэтгэвэрт гаргахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,747,200.0 мянган төгрөгөөр, урсгал зардалд 1,747,200.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2021 онд хийгдэх байсан ажлууд дараа онд хийгдэхээр төлөвлөгдсөнөөс шалтгаалж төсвийг 1,331,603.9 мянган төгрөгөөр бууруулж, 415,596.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр 415,596.1 мянган төгрөгийн төсөв баталсан.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 415,596.1 мянган төгрөгийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлогоос 35.0 мянган төгрөг, нийт 415,631.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 382,520.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 33,110.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 382,520.7 мянган төгрөг буюу 92.0 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 31,921.7 мянган төгрөгөөр, бусад зардлыг 1,153.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийн дутуу зарцуулалт нь Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого хэрэгжүүлэх хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардлыг 33,075.4 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт-2 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мянган төгрөг/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	70805	Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого	415,596.1	382,520.7	33,075.4	92.0%
2	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	398,899.5	365,824.1	33,075.4	91.7%
3	80102	Ажил олгогчоос олгох, тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	13,056.6	13,056.6	-	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь үндсэн 20, гэрээт 1 ажилтантай, захиргаа удирдлагын, мал аж ахуйн, газар тариалангийн үйлдвэрлэлийн гэсэн 3 албанаас бүрддэг.

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 1 хөтөлбөр, 2 арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж, зарцуулсан төсвийн гүйцэтгэл 92.0 хувийн биелэлттэй байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн бодлого хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 3 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ бүхий үйл ажиллагааг төлөвлөн 88.1 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

2021 оны 11 дүгээр сард Дорнод аймгийн Халх гол суман дахь загварын аж ахуйн барилгад засвар хийх зориулалтаар дээд шатны захирагчийн шийдвэрээр 50,000.0 мянган төгрөгийн төсөв хуваарилсныг засварын ажилд 49,449.5 мянган төгрөг зарцуулж, байгууллагын барилга байгууламжийн өртгийг нэмэгдүүлэн бүртгэсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь төв удирдлагаас алслагдсан байршилтайгаас шалтгаалан захиргааны болон бүртгэлээрх хяналтыг сулруулсан. Цаашид нарийвчилсан хяналтын системийг боловсруулж, анхаарч ажиллах шаардлагатай.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 160 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 3 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Дорнод аймгийн Халх гол суманд байрлах загварын аж ахуйн барилгад засвар хийх зориулалтаар дээд шатны захирагчийн шийдвэрээр 50,000.0 мянган төгрөгийн төсөв батлагдсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6-д “*гүйцэтгэгчийн гэрээний үүргийн биелэлтэд чанар болон гүйцэтгэлийн хяналт тавьж, явцын мэдээллийг хагас жил тутамд худалдан авах ажиллагааны цахим системд оруулах*” гэж заасны дагуу мэдээллийг байршуулж, “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ыг мөрдөж ажилласан байна.

Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа нь шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгоогүй, хөрөнгө бэлтгээгүй боловч цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, нэг удаагийн тэтгэмжийн зардлаас бусад зардлын батлагдсан төсөвт 10-аас доошгүй хувь буюу 5,497.4 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын холбогдох заалтуудтай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 9,400.0 мянган төгрөгийн 9 алдаа зөрчлийг арилгах зөвлөмж өгсөн.

Дээрх зөвлөмжийг жилийн эцсийн аудитаар дахин хянахад 8,900.0 мянган төгрөгийн 7 алдаа зөрчлийг арилгаж, 500.0 мянган төгрөгийн 2 зөрчлийн хэрэгжилт хангалтгүй байна. Хэрэгжээгүй 950.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 329,420.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагын биелэлт 100 хувь, 4,200.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүргүүлсэн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	329,420.0	1	329,420.0	-	-	100
Зөвлөмж	1	4,200.0	1	4,200.0	-	-	100
Нийт дүн	2	333,620.0	2	333,620.0	-	-	100

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шүүхийн шатанд явж байгаа газар эзэмшлийн асуудал хэрхэн шийдэгдсэн байдлыг судлаж, газар эзэмшлийн гэрчилгээ нь тус байгууллагын нэр дээр шилжиж ирсэн, санхүүгийн тайлан, бүртгэлд тусгасан эсэхийг хянах;

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,743.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 35.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 1,708.0 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 1,708.0 мянган төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 3,056.1 мянган төгрөгөөс хэтрээгүй тул зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны орлого 35.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн боловч мөнгөн гүйлгээний тайланд үлдэгдлээр тайлагнасан байсныг залруулав.

4.2 Төлбөрийн акт

Тус байгууллага нь улсын төсвөөс сайн дурын даатгалд 420.0 мянган төгрөг төлсөн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

Малчны хариуцлагагүйн улмаас хорогдсон үхрийн үнэ 950.0 мянган төгрөг, загварын аж ахуйн хүлэмжээс хураасан 338.0 мянган төгрөгийн 67 кг нарийн ногоог тайлан бүртгэлд орлого авалгүй үрэгдүүлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил, гүйлгээ, бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, бүх өр төлбөр, аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр, бүх орлого, бүх зардал, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлсийг заавал бүртгэнэ”, гэсэн заалттай нийцэхгүй, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Улсын төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа зөрчил		Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар														
1	Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа	АХГ-2022/350 /НА-СТА-ТШЗ	Улсын төсвөөс сайн дурын даатгал буюу гэнэтийн осол, эмчилгээний даатгал д мөнгө төлж илүү зардал гаргасан.	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах;	1	420.0	-	-	1	420.0	-	-	-	-
2	Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа	АХГ-2022/350 /НА-СТА-ТШЗ	Малчны хариуцлагагүй байдлын улмаас хорогдсон малын үнэ, загварын аж ахуйн хүлэмжээс хураасан ногоог тайлан бүртгэлд тусгаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалтыг хэрэгжүүлж хэвших;	2	1,288.0	-	-	2	1,288.0	-	-	-	-
3	Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа	АХГ-2022/350 /НА-СТА-ТШЗ	Үндсэн үйл ажиллагааны орлогыг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн боловч мөнгөн гүйлгээний тайланд үлдэгдлээр тайлагнасан байсныг залруулав.	УСНББОУС-1	1	35.0	1	35.0	-	-	-	-	-	-
ДҮН					4	1,743.0	1	35.0	3	1,708.0	-	-	-	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал														
1	Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа	АХГ-2022/350 /НА-СТА-ТШЗ	Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 160 мэдээллээс 151 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 3 мэдээллийг байршуулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6 дугаар зүйлийг тус тус мөрдөж ажиллах;	1	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН					1	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ ДҮН					5	1,743.0	1	35.0	3	1,708.0	-	-	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 02 дугаар сарын 25

№ 37 / А0150458

Улаанбаатар хот

АХГ - 2022 / 350 / НА - СТА - ТМЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд болон Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 38 тоот шилжүүлгээр нэр бүхий 21 хүний гэнэтийн ослын даатгалын хураамжид 420,000.00 төгрөг төлсөн, малчны хариуцлагагүй байдлын улмаас хорогдсон малын үнэ 950,000.00 төгрөг төлөөгүй, загварын аж ахуйн хүлэмжээс хураасан 338,000.00 төгрөгийн 67кг нарийн ногоог тайлан бүртгэлд орлого аваагүй үргэдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд аж ахуйн бүх ажил гүйлгээ, бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага, бүх өр төлбөр, аж ахуйн үйл ажиллагааны санхүүгийн эх үүсвэр, бүх орлого, бүх зардал, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартаар тогтоосон бусад зүйлсийг заавал бүртгэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаа улсын төсвөөс сайн дурын даатгалын хураамжид төлсөн 420,000.00 /дөрвөн зуун хорин мянган/ төгрөг, хорогдсон малын үнэ 950,000.00 /есөн зуун тавин мянган/ төгрөг, тайлан бүртгэлд орлого аваагүй нарийн ногооны үнэ 338,000.00 /гурван зуун гучин найман мянган/ төгрөг, нийт 1,708,000.00 /нэг сая долоон зуун найман мянган/ төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал О.Отгонбаяр, нягтлан бодогч М.Энхзаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТӨГС НЯГТ ГУРАВ АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.Наранчимэг
С.Нацагдорж
З.Тунгалаг

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
З.ТУНГАЛАГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9006109
9019120396

\\10.10.10.20\Bichig_kheregv\Akt\2022\0225\Auditin 4 Газар-38.Docx

001090135



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 226/АОС0458
АХГ-2022/350/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 160 мэдээлэл байршуулахаас 6 мэдээллийг хугацаа хоцроож, 3 мэдээллийг иж бүрэн мэдээллээгүй байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн тухай дансны хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, ил тод, бүрэн байршуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал О.Отгонбаяр, нягтлан бодогч М.Энхзаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ТӨГС НЯГТ ГУРАВ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
З.ТУНГАЛАГ

